

Дараах эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Хадат булаг



Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүглийж, түүний хөлд чулуугаар хашиж лайдсан бяцхан худаг газрын нүд болон тормойж байдаг байжээ.

Нэгэн удаа эрлийн хүүхэд ирж, амны цангаагаа гарган сууснаа дүрсгүй зан нь гэнэт хөдлөн, худгийн ёроол руу жижигхэн чулуу унагавал “шол” гэснээ сураггүй болжээ. “Том чулуу шидвэл ямар сүртэй дуугарах бол!” гэж бодон хашлаганых нь бул чулууг арайхийн өнхрүүлж худагт унагавал “пол” гэсэн бөглүү дуу гарснаас өөр дорвитой ч юм болсонгүй. Тэр хүү ямар хэрэг тарьснаа ч ухаарсангүй эрлийн замаа хөөн оджээ.

Болчимгүй зантай хүүгийн бодлогогүй унагасан чулуу худгийн ёроолд унахдаа газрын гүнээс шүүрч байсан булгийн ундаргыг таг даржээ. Удсан ч үгүй худгийн ус ширгэж, хавийн ургамал гуниглан гандаж, саглагар гурван хайлаас хүртэл гиншин хатаж, мөчир нь нүцгэрэн тэнгэрээс хур гүйн сарвайв. Хайлаас дамжин жиргэж байсан богширго нисэн одож, хаа нэгтээ уянгалан байсан дуу эгшиг тасарч, эрэлчин явуулын хүмүүс ч бууж тухлахаа больж, эл хуль болон хоцорчээ.

Хэнэггүй хүний хар гайгаар амьдрал хайрласан булаг хатаж, хадат биш “хадан” булаг болсон нь энэ ажээ.


Н.Өлзийбат, Сэтгэлийн эгшиг, 1991



- 1. Цогцолбор бүрийн утгыг илэрхийлж буй 5 түлхүүр үг (өгүүлэгдэж байгаа юм)-ийг олоорой. Зөвийг сонгоно уу.**

У	Н	Д	А	Р	Г	А
Х	Ү	Ү	Х	Э	Д	Э
Э	Р	Л	И	Й	Н	Л
Х	У	Д	А	Г	А	Х
Х	У	У	Р	А	Й	У
Ч	У	Л	У	У	Л	Л
Ё	Р	О	О	Л	Т	Ь

- 2. Эхийн түлхүүр үг буюу өгүүлэгдэж байгаа юмсын шинжийг харуулсан дүрслэлийг анхаарч эхээс олж уншаарай. Дараах бүдүүвчийг гүйцээгээрэй.**



3. Даалгавруудыг гүйцэтгэхийн өмнө бичлэг үзэж, онолыг ойлголтыг бичээрэй.

Blank area for writing answers to question 3.

Сэдэв гэдэг нь

Дэвшүүлсэн асуудал гэдэг нь

Гол санаа гэдэг нь

4. Бүдүүвчийг анхааралтай ажиглаад, өгүүлэгдэж буй юм буюу түлхүүр үгээр дамжуулан цогцолбор бүрийн сэдвийг тодорхойлоорой. Зөв харгалзуулаарай.

- | | |
|---|-----------------------|
| A. Худаг түүний дүрслэлээр дамжуулан байгалийн унаган төрхийн тухай өгүүлсэн. | 1. 1-р цогцолбор |
| B. Хүүхэд, түүний дүрслэлээр дамжуулан байгалийг сүйтгэгч хүчин зүйлийн тухай өгүүлсэн. | 2. 2-р цогцолбор |
| C. Эл хуль газар, түүний дүрслэлээр дамжуулан байгалийн цөлжилтийн тухай өгүүлсэн. | 3. 3 ба 4-р цогцолбор |

5. Цогцолбор бүрийн сэдвүүдийг ажиглаад, “Хадат булаг” эхийн гол сэдвийг тодорхойлоорой. Зөв хариултыг сонгоно уу.

- A. Байгалийн тухай B. Хүний тухай C. Усны тухай

6. Дээрх эхийн сэдвээр дамжуулан зохиолч ямар асуудлуудыг дэвшүүлснийг тодорхойлоорой.

- A. Байгалийн тэнцвэр алдагдаж буй тухай
B. Цөлжилтийн тухай
C. Хүний бодлогогүй, болчимгүй үйл ажиллагааны тухай
D. Усны нөөц багасаж буй тухай

7. Уг асуудлын дүгнэлт санаа буюу гол санааг тодорхойлоорой. Дараах тайлбарыг гүйцээнэ үү

“Хадат булаг” эхэд зохиолч дэвшүүлсэн асуудлаа дүр, үйл явдлын дүрслэлээр дамжуулан хэмээн дүгнэсэн байна.

- A. Байгалийн тэнцвэр алдагдаж байгаа гол хүчин зүйл нь хүний буруутай үйл ажиллагаа.
B. Хүний бодлогогүй болчимгүй үйлдэл нь өөрийгөө таагүй зүйлд хөтөлдөг.
C. Усны нөөц багасаж байгаа нь байгалийн өөрийн дотоод хүчин зүйлтэй холбоотой.